

УДК 94(517)

АЯЛГУУТ АМАН СОЁЛЫН ЭХ СУРВАЛЖ ДАХЬ ЦУУР, ХӨӨМЭЙН ДУУРСЛЫН ТУХАЙД

Л. Хэрлэн

Ph.D

Монгол Улсын их сургууль, Улан-Батор, Монголия

E-mail: kerlen@yahoo.com

Товч хураангуй

Монгол, Хятадын аман болон бичгийн сурвалж бичгүүд дэх монголчуудын дуу хөгжим, түүний дотор цуурын талаар олон тооны мэдээ баримт байдгийн нэг нь Хятадын Жинь, Хан улсын үед тэмдэглэгдсэн гэх “Түн гэрийн хатагтайн “нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу” буюу “Цуурын магтдуу” юм. Цуур хөгжмийг өгүүлэхийн эрхтэнээс ангид төсөөлөх аргагүй бөгөөд түүний өнгө дуурьслын гол онцлог нь чухам л үүнд оршдог. Учир нь хүн хөгжим хийхээс өмнө хөгжмийн ая эгшгийг дууриан аялаж улмаар өөрийн өгүүлэхийн эрхтэнээ хөгжим болгон, ашиглаж байсны нотолгоо нь монгол хөөмэй болон исгэрэх урлагт тод ажиглагддаг. Тэгвэл цуур хөгжим хөөмэй, исгэрээ хоёрын аль алиных нь элементийг аялгууныхаа бүтцэд хадгалсан байдаг бөгөөд цуурыг цуурдах арга нь исгэрээн дээр үндэслэж байдаг юм. Өнөөдөр ч хүртэл цуур хөгжмийг хэзээ хаана татах, ямар дэг жаягтай байсан нь бас л сонирхууштай. Багахан хурим найр, янаг амрагийн дуу, хөгжмийн хавсрагад хэрэглэдэггүй харин овооны их тахилга, далайц ихтэй найр наадамд л гол төлөв хэрэглэгддэг онцлогтой. Эл уламжлал одоог хүртэл бараг эртний хэлбэрээр хадгалан бидэнд өв уламжлагдаж ирсэнд бахархууштай. Мөн цааш уламжлан авч хадгалж хөгжүүлэх хэрэгтэй байгаа бөгөөд судлагдахууны эх хэрэглэгдэхүүн хэвээр нээлттэй байгаа билээ.

Түлхүүр үг

“Цуурын магтдуу”, монгол дуу хөгжим, сурвалж бичиг, цуур, хөөмэй, дуурьсал, эгшиглэгээ

UDC 94(517)

TSUUR AND KHUMEI IN THE SOURCES OF ORAL CULTURE

Kherlen L.

Ph.D

National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

E-mail: kerlen@yahoo.com

Annotation

There are many sources of Mongolian music in Mongolian and Chinese oral and written sources, including the Tsuur. "Echoes cannot be imagined without the organ of speech, and this is the main feature of their color imitation. This is because the evidence that a person used to imitate the sound of music before making music and then used his or her speech organs as music can be clearly seen in Mongolian throat singing and whistling. The percussion music retains elements of both the harmonica and the whistle in the structure of the melody, and the percussion method is based on the whistle. Even today, it is interesting to see when and where the percussion was played and in what order. It is not used for small weddings, love affairs, or music, but is usually used only for large ovoo rituals and large-scale festivals. We are proud that this tradition has been preserved in an almost ancient form and passed down to us. It also needs to be preserved and developed, and the source material is still open.

Keywords

"Praise of the Tsuur", Mongolian music, source script, Tsuur, khumei, imitation, vowel

УДИРТГАЛ

Эртний Хүннү гүрний үед цуур нилээд өргөн тархаж, монголчуудын уламжлалт хал¹ хөгжмийн зэмсэг аман соёлд холбоотойгоор баримтжуулжээ гэж үзэж болохоор байна. Хятадын түүхэн сурвалж бичиг баримтад цууртай холбоотой “Шиаогийн магт дуу” гэж байх ба “Хятадын Чүн-чиүгийн үеийн Жинь улсын Чэн Гүн шиаогийн хөгжмийг сонсож нэг бадаг “Шиаогийн магтдуу” бичив” гэсэн байдаг байна. Үүнийг Өвөрмонголын Их сургуулийн урлаг судлалын ухааны доктор, професор Э.Гэрэлт бичихдээ: “Цуурын магтдуу” нь Хятадын Жинь² (Хятадын хөгжмийн зэмсэг 2005: 56) улсын үед тэмдэглэгдсэн 2660 гаруй жилийн түүхтэй”³ гэсэн бол Шинжааны Их сургуулийн доктор, профессор Фү.Мэргэжих цуурын талаар бичсэн хэд хэдэн өгүүллээ “Шинжааны монголчууд модон цуур гэх үлээх төрлийн хөгжимдүүр лүгээс ялгахуйн тулд “хоолойн цуур” гэж дуудан дассан байдаг гээд “газар нутгийн байршлын хувьд хоёр өөрөөр нэрлэгдсэн хэдий ч дуу хөгжмийн нэршлийн дүрмийн үүднээс Монгол улсын хөөмэйн язгуур нэрээр “хөөмэй” гэж нэрлэх нь зүйтэй юм” (Мэргэжих, 1997: 409) гэж тэмдэглэжээ. Тэрээр цааш цуурыг хоолойн, модон гэж ангилахдаа модон цууртаа хөгжмийн зэмсгийг заасан бол хоолойн цуураа “монгол дууны хоршил дуулах арга” гэж нэрлээд алтайн цуур нь монгол хөгжимдүүрийн өвөг үүслийн эх гэж бичсэн байна.

Шиаогийн талаар чухам аль үед юуг тодорхойлон бичсэн, аялгуут аман соёлд хэрхэн холбогдох эсэх талаар тодотгох үүднээс судлаачдын тэмдэглэлийг чухалчилж харьцуулан авч үзье. Чухам “*шиао*” гэж юу вэ? Өвөрмонголын их сургуулийн доктор, професор Фү. Мэргэжих шиаог “цуур” (Мэргэжих, 1986; 1988) гэж тэмдэглэсэн байдаг бол урлаг судлаач, хэл шинжээч Ж.Бадраа шиаог нэгэн төрөл үлээвэр хөгжмийн зэмсэг бишгүүртэй, нөгөө нэг нь чавхдаст хуурын нэр төрөлд хамааруулан тайлбарлажээ. Тэрээр: “Шиао гэдэг нэртэй нэгэн зүйл үлээвэр хөгжмийн зэмсгийг Солонгост хучин гэж байсан гэж Еберхард мэдээлсэн. Шиао чухамдаа сумны зэв гэсэн утгатай. Энэ нь Хүннүгийн “дуут сумыг” аргагүй санагдуулж байна. Магадгүй бас шиао нь хятад бус умар зүгийн гаралтай хөгжмийн зэмсэг байсан байж болно. Шиаогийн монгол нэр бишгүүр “хисгэр-исгэр” гэдэг үгтэй холбоотой. Монголын цуур гэдэг үг дан ганц үлээвэр хөгжмийн нэр биш, мөн чавхдас хөгжмийн зэмсгийн нэр байсан. Жишээлбэл, саяхан болтол одоогийн Баянхонгор аймгийн ард олны хэрэглэж байсан янгирын шөрмөсөөр хийсэн зургаан чавхдастай жижигхэн ятгыг “шөрмөсөн цуур” гэдэг байжээ. Бас А.Д. Руднев “Дорнод монголын аман аялгууны хэрэглэгдэхүүн” гэдэг номдоо жастуу аялгуугаар: “шоор гэж хоёр чавхдастай хийл, хоороос ялгаатай нь нум нь чавхдасныхаа хоорондуур ордоггүй, чавхдсыг нь чөрмөсөөр биш хялгасаар хийдэг. Тан Улсын Хятадад бас хоёр ихэр хөгжмийн зэмсэг бийбаагийн загвараар үйлдээд “да хулэй, шиао хулэй” буюу их хуур, бага хуур гэж нэрлэжээ” гэжээ (Бадраа, 1998: 92-93) .

¹“хал” гэж Ж.Бадраа, Г.Бадрахын зохиолуудад байх нь хуучны эртний гэсэн утгыг агуулах бөгөөд одоо бараг хэрэглээнээс гарах дөхсөн халагдаж өнгөрсөн гэдгээр тэмдэглэгдсэн болов уу.

²“Хятадын Жинь улс нь МЭ 265-МЭ 420 оны үед оршин тогтнож байсан улс” хэмээн тайлбарлажээ. “; “Монгол дуу хөгжмийн судлал” Шинжян, 1997, 70, 92, 161, 190, 341.

³Гэрэлт Э. Хөөмэйн урлагийн үүсэл, тархалт хөгжилтийн тухай миний үзэлт Өвөрмонголын Их сургуулийн Эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл, 2003.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА

Дээрх Ж. Бадраа гуайн нэр тайлбарын шоорын тухайд гэвэл цуурын нэр төрөлд хамаатуулан үзэх нь зүйтэй болов уу. Жостын аялгуу гэдэг нь “Өвөр монголын Хянган аймгийн Дөрвөд бэйсийн хошууны Жостын чуулганы аман аялгуу”¹ -нд багтах бөгөөд уугуул нутгийн ша-тан аялгуутны хэллэгээр “ц” авиаг “ш”-ээр дуудаж (цамц-шамш, цагаан-шагаан, цус-шут, цуу-шуу гэх зэргээр) нэрлэдэгээс үзвэл шоор гэдэг нь үндсэндээ цуурыг нэрлэж байгаа нэр томъёо юм. Мөн Өвөр монголчуудын зарим нутаг хорчин, шинжианы зарим угсаатан хөөмэйг хоолойн цуур гэж нэрлэдэг. Харин монголчуудын дунд модон цуур, хөөрөгт цуур, хотон бишгүүр зэрэг зэмсэг нь үлээвэр хөгжмийн нэгэн төрөлд хамруулах, шөрмөсөн цуур, туг цоор, ихэл цуурууд нь тов-шуур, утсан, нумт хөгжмийн төрлүүдэд хамаарагдах цуурын нэр нэрлэгээ бүхий олон хөгжмийн зэмсэг бий. Эгшиглэх арга барил, дуурьсал, нэр төрлийн хувьд цуур нь хүний өгүүлэхийн эрхтэнтэй шүтэлцэн хөөмөйтэй холбогдох учир дээрхи зарим цуу-рын нэрс бүхий хөгжмүүдтэй шууд холбогдохгүй болов уу. Учир нь цуур хөгжмийг монгол ардын хөгжмийн өгүүлэхүйн эрхтэнтэй шүтэлцээт урлаг мөн уриа дуудлагын ая аялгууны аймагт хамруулан, хүний өгүүлэхийн эрхтэн хөгжмийн зэмсгийн үүр-гийг гүйцэтгэх хөөмэй төст авиан дээр хөгжмийн зэмсэгтэй хавсран хөгжмийн эгшиг үүсгэх, “хөгжим үүсгэх” үзэгдлийг буй болгодогоороо цуурын онцлог гайхамшиг нь тодорхойлогдоно. Мөн хоолойн цуур гэж ая аялгууны нэгэн хэлбэр өвөрлөгч нарын дунд байдгийг найрын дууны төрөлд хамаатуулан авч үзэх боломжтой.

Харин Еберхардын тайлбар дахь “дуут сум, сумын зэв, умардын Хүннү нарын хөгжмийн зэмсэг” гэсэн нь нэлээд сонирхол төрүүлсэн юм. Энэ нь “цуур”-ыг эгши-глэгээний талаас нь хөөмэйн аялгуутай илүүтэй хамруулан үзвэл зохилтой мэт санагдаж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хятадын түүхэн бичигт тэмдэглэгдсэн шиаог юу гэж тайлбарласныг иш татан авч үзье.

Хятад хэлний толь бичигт: *нэг дэх утга нь:*

– хүнээс гарах дуу авиа, исгэрэх, хархирах
– адгуусан амьтнаас гарах авиа, барс урхирах, арслан хүрхрэх, адуу унгалдах, шувуу жиргэх

– байгалийн чимээ, салхины исгэрээ техникийн дуу чимээ, машин, онгоцноос гарах хүнгэнээ (Хятадын одоо үеийн толь бичиг, 1978: 1273) гэж тайлбарласан бол,

Хоёр дахь утга нь: “Ху-гийн нэгэн зүйл үлээвэр хөгжмийн зэмсэг, эрт үед олон хулсыг зэрэгцүүлэн үлээдэг байсан бол одоо үед ганцаар нь үлээх болсон” (Хятадын одоо үеийн толь бичиг, 1978: 1268) гэжээ. Бас хятадын толь бичгүүдэд “шиао”-г “хуу жиа” гэх агаад энэ нь “модон цоор” гэж тэмдэглэсэн нь бий.

Дээрхи шиаогийн талаарх утга тайлбар нь нэг талаар хүн, адгуус, байгаль, техникээс гарах ямарваа хүнгэнэн, исгэрэх дуу чимээ, авиаг нэрлэсэн гэж тайлбар-лагдаж байгаа нь Еберхардын: “шиао чухамдаа “сумын зэв” гэсэн утгатай, Хүннү-гийн “дуут сумыг” арга буюу санагдуулж байна” гэдэг тайлбартай утга нэг байгаа

¹Хэл шинжлэлийн ухааны доктор /Sc.D/ Г.Гантогтохын тайлбар, 2005:11:22-нд.

нь сонирхолтой. Магадгүй хүн ан агнах гэж ангаа отон сууж, андаа нум сум тавих агшинд гарсан нумнаас гарах чимээ, авианаас хөгжмийн эгшиг үүсгэх анхны санаа авч улмаар чадхдаст болон утаст хөгжмийн үүслийн эхлэл бий болсон гэдэгтэй нэгэн адилаар аливаа байгалийн юм уу амьтны исгэрэх дуу чимээнээс цуур үүссэн байж болох талтай.

Эрдэмтэд урлагийн үүслийг “хүн анд гарах, анхныхаа анг агнасан сэтгэлээ илэрхийлэн гаргахдаа янз бүрийн хөдөлгөөн хийх болсноор бүжиг, отог омгийнхоо гал манан шөнөжин суух зуураа ая аялгуу гиншин дуугарах болсноор дуу үүссэн, аливаа байгаль, эд зүйлс, амьтнаас гарах дуу чимээг үлгэрлэн хүн анх хөгжмийн зэмсэг үүссэн” гэх тухай олон эрдэмтдийн саналуудтай цуурын үүслийг адилтган үзэж болох талтай. Тухайлбал: Оросын сэтгэгч Г.В.Плеханов “Хаяггүй захидлууд” гэдэг бүтээлдээ, урлагийн үүсэл хүний биет үйл ажиллагаатай шууд холбоотой: “Эртний хүмүүс галаа тойрон бүжиглэж байгаа хөдөлгөөн нь ан агнахад хэрэглэсэн үйл хөдлөлөө дахин давтаж, түүгээрээ баясаж буйн илэрхийлэл болдог байна. Энэ бол хөдөлмөрийн хөдөлгөөн нь урлаг болон илэрч буй хэлбэр мөн. Өнөөдөр ч энэ байдал бидний дунд үргэлжилсээр байна. Жишээ нь өнөөдөр эскимосчууд далайн хавыг хэрхэн агнадгийг харцгаа л даа” (Плеханов, 1956: 93) гэсэн бол “байгалийн сонин сайхан дуу авиаг дууриаж хүн хөгжмийн эх сурвалжийг үүсгэхдээ мод, чулуу, хулс, зэгс зэргийг хөгжмийн зэмсэг болгон ашиглаж анхны болхи бүдүүн хийцтэй бүрээ, цуур, бишгүүр, аман хил үйлдэж байсан цагаасаа өөрсдийн гар доор байгаа хэрэгсэл болох нэгэнт боловсорсон өгүүлэхийнхээ эрхтэнг ашиглаж байсан” (Бадраа, 1998: 42) гэснээс ишлэл татаж тодотгож болох байна.

Эндээс үзвэл аялгуут аман соёлын зүйлс нь байгалийн салхи шуурганы исгэрээн, гол мөрний шуугиан мэт байгалийн дуу чимээг үлгэрлэн, шувуудын жиргээ, ховших, хүүхэд уйлах болон хүн малын явдлыг дүрслэн дууриаж, тэдгээр дуу авиаг орлуулах аливаа байгалийн эд зүйлийг ашиглах болсноор эх үүсвэр нь тавигджээ. Тэгэхдээ хүн, байгаль орчиноо ухамсарлан харьцаж эхэлсэн харьцааны үр дүнд тухайлбал хүн байгалийн гоо сайхныг ухаарч түүнээ урлахуйн аргаар илэрхийлэх гэсэн үйл ажиллагааны бүтээгдэхүүн, байгалийн гоо сайхныг ухаарахдаа байгалийг бишрэн шүтэх шүтлэгээс ангижраагүй байсан эрт цагт, энэ бүл хөгжмийн зэмсгийн анхны бүтээврүүд буй болжээ гэж үзэж болох байна.

Хөгжмийн анхны хэлбэр гэж болох зарим төрөл хөгжмийн зэмсэг монгол анчдын дунд бий. Энэ нь анчин анг дуудахдаа зөвхөн анг агнах төдийд бус ангаа ажих, ангаа аргадах эргэл мөргөлийн хэлбэрээр ч хэрэглэдэг байсан урам юм. Тэгэхдээ аливаа ан гөрөөсний дууг дууриан чимээлэхдээ анчин хүн нэг бол дан ганц өгүүлэхийнхээ эрхтнээр үйлдэх, эсхүүл өөр биет материаллаг зүйлийг өгүүлэхийн эрхтэнтэйгээ хослуулан хэрэглэх гэсэн хоёр зүйлийн аргыг хэрэглэдэг байсан байдаг. Тухайлбал: “ан автай холбоотой чоно хандгайн уриа, амьтны дуу хоолойг дууриан бархирах, архирах, шогшрох, шившүүрдэх ан агнуурын уриа дуудлагын зан үйл” (Гантогтох, 2007: 147) анчид, бөө мөргөлийн аливаа зан үйлд хадгалагдан үлджээ. Энэ талаар зарим нэг баримтыг товч дурьдвал: ”янгирь агнахдаа “агирдаг”, аргал угалз, сарлагийг “бөлбөөлдөг”, бор гөрөөсийг урихдаа “шившүүрдэх”, чоныг урихдаа “улих”, үнэгийг дуудахдаа “шовшрох”, бугыг дуудахдаа “урам” гэж үйс хуйлж хийсэн нэгэн зүйл бүдүүн борог материаллаг бүтээвэрийг үлээвэр хөгжмийн зэмсэг мэт болгон

урамддаг. Ийм төрлийн хэрэгслийг “шовшуур”¹ гэж нэрлэн түүнийгээ үлээхдээ “шовшуурдах” гэдэг байв. Энэ нь анг дуудах ая дуу үүсгэх нь уг ангийн дууг яг дууриан гаргах гэсэн гол зорилготой бөгөөд үүнийгээ ч чадамгай эзэмшсэн хүмүүс нь монгол анчид, малчид байсан нь тодорхой. Энэ бүх монголчуудын хөгжмийн эхийн уламжлал хөгжим хөөмэйтэй хосолсон хэлбэрээр цуурт хадгалагдан үлджээ.

Бугын урамдах дуурьслыг үлгэрлэж чадах хэрэгслийг хийсэн анчны урам нь буга намнахад хэрэглэдэг нэгэн зүйл соруул хөгжмийн зэмсэг лугаа зүйлийг үйлдэхдээ хус модыг хөндийлж ухан соруул гаргах буюу эсвэл хус модны үйсийг (холтосыг) хуйлан дуран авай мэт сунган сорж татах үйлдлээр ашигладаг эл зэмсгийг анчны урам хэмээн нэрлэх бөгөөд алтайн урианхайчууд, анчид элбэг хэрэглэх ба мөн хонины шагайт чөмгөөр ч урам хийж хэрэглэдэг уламжлал байна. Энэхүү хялбар дөт нэгэн төрөл хөгжмийн зэмсэг хөгжим үүсэж бий болох хөгжлийн явцад эгшиг авиа нь уриа дуудлагын хэлбэртэй байснаа хөгжмийн хөгжлийн явцад улам боловсронгуй болж цуур гэх биеэ даасан хөгжмийн зэмсгийн төрлийг бий болгосон байж болох байна. Цуурыг өнөөдөр уриа дуудлагын ая аялгуу, өгүүлэхүйн шүтэлцээт хөгжмийн зэмсэгт хамруулан үзэхийн хувьд хөгжлийн явцдаа хөөмэйн эгшиг авиаг хамсруулан хүний өгүүлэх эрхтнийг дээд зэргээр хөгжүүлэн баяжуулах явц эрт үеэс монголчуудын дунд боловсорсон гэж үзэх үндэслэл байгааг харуулж байна.

Бидэнд зөвхөн хөгжмийн нэр төрлөөс гадна “Шиаогийн магтуу”-нд тэмдэглэсэн: “гундагууны тунгалагаар жидугууныг тодруулан, шандууны цээлхэнийг жидуун дур найржухуй” гэсэн эртний монгол хөгжмийн тэмдэглэгээгээр бичигдсэн тэмдэглэл нь тэр үеийн хөөмэйн дуугарах багтаамж, хөг аялгуу өнөөдрийн хөөмэйн үндсэн хөг хөглөгөөтэй ижил болон ялгаатай талуудыг харьцуулан гаргах сонирхол төрүүлсэн юм. Эх зохиолдоо:

“...Уран эгшиг улаан уруулаас үүсэж
Уяраан дуун цагаан шүднээс гармуй
Цуурай ану тунгалаг бөгөөд эевэргүү
Цог ану цэлгэр бөгөөд дүрэлжүүн
Гундагууны тунгалагаар жидугууныг тодруулан
Шандууны цээлхэнийг жидуун дур найржухуй
Шилжих үүлийг агаар мандал дур дэгдээгээд
Ширүүн салхийг түмэн газраас хуруйлмуй
Шимт бодьгалийн туйлын эгшиг буй за
Ширхэг хулсны дуун бус ажгуу
Тийнхүү дууныг зэмсэг дур түшихгүй
Эд хэрэглэл дор найдахгүй
Дөхөм дөт биеэсээ авч
Сэтгэлийг зарж, амьсгал хэрэглэж
Уруул хөдөлгөөнөөс аялгуу болж
Ам нээвээс дуун үүсэж
Юмыг үзэн бодис дур ягтлан
Дуун аяар исгэрэл дагаж
Бялар бишгүүрээс яруу тунгалаг
Ятга ширхэгээс уяхан цээлхэн

¹Шовшуур гэж казак ард түмний цуур хийдэг модлог ургамалын нэр /сыбызки/.

*Хүрхрэн шуугих салхи үүсэж
Янцгаан үүрсэх дуун гарах ану
Ар газрын хөлөг морьд
Нутаг юугаа мөрөөсөж
Хүйтэн салхинаа
Умарш хандан үүрсэх мэт...
“...Хун галуу өндөр дуунаар ганганан
Олон шувууд говь цөл дур жиргэх адил
Тийнхүү дүрсийг үзээд дуун үүсэж
Хэрэг тур игтэлж аялгуу бүтээмүй”
гэжээ (Мэргэжих, 1988: 4; Эрдэнэчимэг, 2002: 98).*

Энэхүү түүхэн тэмдэглэлээс “Хүрхрэн шуугих салхи үүсэж, янцгаан үүрсэх дуун гарах ану ар газрын хөлөг морьд нутаг юугаа мөрөөсөж, хүйтэн салхинаа умарш хандан үүрсэх мэт” гэсэн нь Еберхардын “Магадгүй бас шиао нь хятад бус умар зүгийн гаралтай хөгжмийн зэмсэг байсан байж болно” гэдэгтэй таарч байх төдийгүй Хятадын хойд нутгаар нутагладаг үндэстний дунд нэлээд түгээмэл хэрэглэгдэж байсан “**шиао**” хэмээх хөгжмийн зэмсгийн дуурьслын талаар өгүүлсэн нь бидний сонирхолыг татсан юм.

“Шиаогийн магт дуу”-нд тэмдэглэснийг дэлгэрүүлэн тайлбарлавал: “Уран эгшиг улаан уруулаас үүсэж, уяраан дуун цагаан шүднээс гармуй, ширхэг хулсны дуун бус ажгуу, цуурай ану тунгалаг бөгөөд ээвэргүү, цог ану цэлгэр бөгөөд дүрэлжүүн” гэсэн нь хүний өгүүлэхүйн эрхтэнээс гарч буй эгшиг авиа, хүн уруулаар үлээж эгшиг үүсгэхийг нэрлэж байна. Дараа хулсны дуу мэт тунгалаг, цоглог, цэлгэр гэдэг нь бишгүүр, цоор, цуурыг хулсаар үйлдэж аялгуу гаргадаг гэдэгтэй санаа нэг аливаа үлээвэр хөгжмийн эгшиглэгээ мэт ая аялгуутай гэж тодорхойлжээ. Цааш нь “дууныг зэмсэг дур түшихгүй, эд хэрэглэл дор найдахгүй” гэсэн нь тэрхүү дуу эгшиглэгээг гаргахдаа ямар нэгэн хөгжмийн зэмсэг, эд хэрэглэлээр гаргахгүй гэжээ. Энэ нь: “дөхөм дөт биеэсээ авч, сэтгэлийг зарж, амьсгал хэрэглэж уруул хөдөлгөвөөс аялгуу болж, ам нээвээс дуун үүсэж, юмыг үзэн бодис дур ягтлан, дуун аяар исгэрэл дагаж, бялар бишгүүрээс яруу тунгалаг, ятга ширхэгээс уяхан цээлхэн” гэсэн нь аялгууг бие, сэтгэл, амьсгаагаар үйлдэх агаад уруул ам нээж дуун исгэрэл үүсгэж тэрхүү дуу нь бялар, бишгүүр, ятга зэргээс яруу тунгалаг цээлхэн гэжээ.

ҮР ДҮН

Дээрхээс ажиглан үзвэл өгүүлэгдэж буй зүйл нь одоо бидний мэдэх цуур хөгжмийн нэгэн төрөл эсвэл тэр хөгжмийн бүтэц, хэлбэр биш харин хүний өгүүлүүрээр үүсэх эгшиглэгээний талаар бичжээ. Тэгэхдээ цуур болоод хөөмэйлэх үйл явцтай ойролцоо хүн өөрөө хөгжмийн зэмсэг болж яруу тунгалаг ая аялгуу үүсгэх гэсэн ойлголтыг өгч байна. Тиймээс дээр өгүүлсэн Хан улсын бичигт тэмдэглэсэн Хүннү нарын хөгжим гэдэгт гардаг хэл хоолой руу матарч орон ая аялгуу үүсгэдэг, энд өгүүлэгдэж байгаа ямар нэгэн зэмсэг, эд хэрэглэлд найдахгүйгээр ая аялгуу үүсгэдэг зэргээс үндэслэн хөөмэйн аялгуу үүсгэдэг гэдэг нэгэн санаа гарч болох байна.

Нөгөө талаар Хүннү нарын дунд уриа дуудлагын ая аялгуутай холбоотойгоор түүхэн тэмдэглэлүүдэд бичигдсэн хулсны навч ороон үлээх, чулуугаар цуур татах

зэрэг нь хөөмэй төст эгшиглэгээ үүсгэдэг байсан гэх санаа гарч ирж байна. Энэ нь хөөмэй болоод цуурын эгшиглэгээний талаар бүр эрт Хүннүтэй холбоотой түүхэн сурвалжуудад тэмдэглэгдэн үлдсэнийг харуулж байна. Өнөөдөр бидний ойлгож ирсэн цуур хөгжим нь хөөмэйн урлагтай холбоотой харилцан уялдан уламжилж ирсэн эх суурь нь Хүннүгийн үеэс эхлэлтэй байжээ гэж ойлгогдож байна.

Мөн “Шиаогийн магтуу” зохиолд: *“гундагууны тунгалагаар жидугууныг тодруулан, шандууны цээлхэнийг жидуун дур найржухуй”* гэсэн эгшиглэгээний дуурьслыг тэмдэглэсэн нь бий.

Монголчууд дуун илэрхийлэх эгшгийн утгыг илэрхийлэх, ялгах тусгай нэрээр томъёолсон нь бий. Тухайлбал: гундагуун-гундуун, гидагуун-гидуун, жидагуун-жидуун, юдагуун-юудуун” (Цэвэл, 1966: 166) гэж таван эгшигтийн зарчимд хамааруулан “жидагун-идэт дуун, гүндэгүн-хүнгэнэх дуун, шандагун-цангинах дуун, юдагун-жингэнэх дуун, гиодагун-гингэнэх (цуурын дуу) гэдэг гээд улаан (гал), шар (шороо), цагаан (төмөр), хар (ус), хөх (модон) өнгө махбодын таван эгшигт тулгуурласан” (Бадраа, 2005: 58) хэмээн тайлбарлажээ.

Юань улсын, тухайлбал Хувилайн хаанчлалын үед ордонд олон төрлийн хөгжмийн зэмсгүүд хэрэглэгдэж байсан ба дуу хөгжмийн нийт аялгыг таван эгшигт хувааж тодорхой нэр зааж:

“Нэгдүгээрт “гүндээхүн”¹ (Цэвэл, 1966: 166) буюу туйлын нам, туйлын булингар.

Хоёрдугаарт “сандахун” буюу дэд нам, дэд булингар.

Гуравдугаарт “гидахуун” буюу өндөр нам тунгалаг булингар.

Дөрөвдүгээрт “жидаахуун” (Цэвэл, 1966: 240) буюу дэд өндөр, дэд тунгалаг.

Тавдугаарт “юудагуун” буюу туйлын өндөр, туйлын тунгалаг гэх мэтээр нийт 12 хөг байх бөгөөд түүний зургаа нь “Арга” хөг, зургаа нь “Билиг” хөг болно (Дашдорж, Цоодол, 1971: 28) гэж томъёолон нэрлэж, аргыг “бодис”, билгийг, “сэтгэл” болгож идеалист сургаалаар томъёолон тайлбарласан зүйл энэтхэгийн гүн ухааны номд бий гэж Дамдинсүрэн багш “Зуун билэг”-ийнхээ 486-р талд тайлбарласан тухай ч бий.

Энэхүү эртний дорно дахины эгшиг тэмдэглэгээг өрнийн хөгжмийн онолын судлагдахуунтай харьцуулан тодорхойлж болох авч өнөөдөр баттай судлагдсан судлагаа хараахан боловсроогүй байгаа юм. Гэсэн хэдий ч эх зохиолд гарч байгаа эгшиглэгээний дуурьслын тэмдэглэгээнээс цуурын дуу /гиодагун-гингэнэх/ хэмээх тайлбар нэг талаар таарч байгаа бөгөөд нөгөө талаар нам, өндөр, булингар тунгалаг гэх мэт эдүүгээчлэн тайлбарласан тайлбараар хэд хэдэн эгшгийн дуурьслыг найруулан эгшиглүүлэх гэсэн шууд утгаар авч үзэх боломжтой мэт санагдана. Учир нь өнөөдөр хөөмэйн суурь эгшиг дээр суурилж цуурддаг уламжлал хадгалагдаж ирсэн бөгөөд бас хоолойн цоор хэмээх өвөрлөгч монголчуудын дунд хөөмэй төст эгшиглэгээгээр суурилж уртын дуу дуулах уламжлал бий.

Үүнээс үндэслэн Монголчуудын Хүннү гүрний үеэс хөөмэй нь цуурын ая аялгуунд хадгалагдан өөрийн өнгө эгшиглэгээгээр дуурьсаж байсан төдийгүй тэр үеийн эгшиг тэмдэглэгээгээр бичиж үлджээ гэж хэлж болмоор байна.

¹“хуучирсан таван эгшгийн нэр” гэж тайлбарлажээ.

ДҮГНЭЛТ

Тэгэхээр дээрх “Шиаогийн магтуу” буюу “Цуурын магтуу” өгүүлэгдэх цуур нь Монголчуудын эртний өвөг Хүннүчүүдийн үед тэмдэглэж үлдээсэн тэр үед анхан хэлбэр нь ангийн зориулалттай байснаа цэргийн хөгжимд уриа дуудлагын хэлбэрээр хэрэглэгдэж байжээ. Сүүлд Их хаадын ордны хөгжимд бүртгэгдээгүй хэдий ч цэргийн хөгжмийн нэгэн хэлбэрээр бараг мартагдах шахсан хөгжмийн зэмсэг хэмээн тэмдэглэгдэн үлджээ. Дараа нь ард түмний дунд туульд зарим уул усны магтаалд дурьдагдан уламжилсан байна. Тэгэхдээ уриа дуудлагын шинжээ хадгалан хөөмэйн эгшиглэгээтэй цуг хавсарсан хэлбэрээр аялгуулсаар өнөөг хүрчээ гэсэн дүгнэлтэнд хүрч болох байна.

Ном зүй

- Бадраа, Ж. (1998). *Монгол ардын хөгжим*. УБ.
Бадраа, Ж. (2005). *Ардын билиг ухааны оньс*. УБ.
Гантогтох, Г. (2007). *Монгол зан үйлийн аман яруу найргийн уламжлал*. УБ.
Дашдорж Д., Цоодол С. (1971). *Ардын дуу хөгжмийн суу билэгтнүүд*. УБ.
Мэргэжих Фү. (1986). *Хоолойн цуурын нууц. Талын дуулал сэтгүүл*. Хөх хот, № 6.
Мэргэжих Фү. (1988). Цоорын үзэгдэл болон цоорын хөгжим. *Шанхайн хөгжмийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*, № 2.
Плеханов Г.В. (1956). *Письма без адреса*. М.
Хятадын хөгжмийн зэмсэг. 2005
Хятадын одоо үеийн толь бичиг (1978). Шинжян, № 1.
Цэвэл Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*. УБ.
Эрдэнэчимэг, Л. (2002). *Гүн гэрийн хатагтайн нүүдэлчдийн цуурын арван найман аялгуу*. УБ: Адмон.

References

- Badraa, Zh. (1998). *Mongolian folk music*. UB. (in Mongolian).
Badraa, Zh. (2005). *The secret of folk wisdom*. UB. (in Mongolian).
Gantogtokh, G. (2007). *Mongolian ritual oral poetry tradition*. UB. (in Mongolian).
Dashdorj D., Tsoodol S. (1971). *Spiritual geniuses of folk music*. UB. (in Mongolian).
Mergezhikh Fu. (1986). The secret of the throat Tsuur. *Steppe hymn magazine*. Hohhot, 6. (in Mongolian).
Mergezhikh Fu. (1988). Tsuur phenomenon and music. *Scientific Journal of Shanghai Conservatory of Music*, 2. (in Mongolian).
Plekhanov G.V (1956). *Letter without address*. M. (in Russian).
Chinese musical instruments. 2005. (in Mongolian).
Modern Chinese Dictionary (1978). Xinjiang, 1. (in Mongolian).
Tsevel Ya. (1966). *Concise Mongolian Dictionary*. UB. (in Mongolian).
Erdenechimeg, L. (2002). *Eighteen melodies on the Tsuur for nomads*. UB: Admon. (in Mongolian).